МЭДЭЭ · 2023 оны 11-р сарын 7

ШҮҮГЧ, ӨМГӨӨЛӨГЧДИЙН ХАРААТ БУС БАЙДЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН НҮБ-ЫН ТУСГАЙ ИЛТГЭГЧТЭЙ УУЛЗАЛТ ХИЙЛЭЭ



Монгол Улсын ерөнхий прокурорын орлогч М.Чинбат Шүүгч, өмгөөлөгчдийн хараат бус байдлын асуудал хариуцсан НҮБ-ын тусгай илтгэгч Маргарет Саттертуэйт тэргүүтэй төлөөлөгчдийг өнөөдөр /2023.11.07/ хүлээн авч уулзлаа.

Уулзалтаар Монгол Улсын прокурорын байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл, хараат бус, бие даасан байдлын талаар ярилцаж, Тусгай илтгэгчээс тодруулсан асуудлаар мэдээлэл өглөө.

НҮБ-ын тусгай илтгэгч Маргарет Саттертуэйт тэргүүтэй төлөөлөгчид мөн Сэлэнгэ, Дархан-Уул аймагт ажиллаж, холбогдох байгууллагатай уулзалт хийх аж.



Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1331